



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/216/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН МОНГОЛ ТУУРГАТАН ТЕАТРЫН 2022 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 01/73
танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Монгол Туургатан театрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Монгол Туургатан театрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Монгол Туургатан театр нь мэргэжлийн урлагийн байгууллагын уран бүтээлийн чанарыг сайжруулж, уламжлалт үндэстэн ястны бахархалт уран бүтээлүүдээр урийн санг баяжуулан, үзэгчдийн хүртээл болгох зорилго зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Тайлант онд нэг бүтээл сэргээн, гурван бүтээлийг шинээр найруулан тавьж, нийт дөрвөн уран бүтээлээр урын сангаа баяжуулан 12716 иргэнд үйлчилсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	395,655,374.42	345,929,749.83
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0	4,092,804.56
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0	4,092,804.56
31210	Төгрөг	0	4,092,804.56
31211	Төрийн сангийн харилцах	0	4,092,804.56
33	АВЛАГА	1,995,247.32	2,348,602.17
33500	Бусад авлага	1,995,247.32	2,348,602.17
33510	Байгууллагаас авах авлага	1,365,247.32	2,025,025.52
33520	Хувь хүмүүсээс авах авлага	630,000.00	323,576.65
35	БАРАА МАТЕРИАЛ	393,660,127.10	339,488,343.10
35100	Түүхий эд материал	324,477,481.00	272,029,753.00
35110	Тусгай зориулалттай материал	324,477,481.00	272,029,753.00
35400	Хангамжийн материал	69,182,646.10	67,458,590.10
35410	Бичиг хэргийн материал	3,851,330.00	3,851,330.00
35420	Аж ахуйн материал	63,696,316.10	53,575,260.10
35430	Сэлбэг хэрэгсэл	1,635,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	0	10,032,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,871,863,177.77	9,153,142,803.82
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,871,863,177.77	9,153,142,803.82
39200	Биет хөрөнгө	9,555,738,177.77	8,912,137,803.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	10,070,092,656.94	9,514,556,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-601,638,509.45	(647,308,473.12)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	84,920,000.00	84,920,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-84,920,000.00	(84,920,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	156,695,333.70	139,769,313.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	-128,709,826.78	(124,324,760.16)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	202,552,105.64	172,552,105.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	-143,253,582.28	(143,106,382.24)
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,884,285.70	15,884,285.70
39215	Хуримтлагдсан элэгдэл	-15,884,285.70	(15,884,285.70)
39300	Биет бус хөрөнгө	316,125,000.00	241,005,000.00
39301	Програм хангамж	600,000.00	2,280,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-600,000.00	(600,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	316,125,000.00	239,325,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,267,518,552.19	9,499,072,553.65
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	8,117,982.04
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	8,117,982.04
41300	Өглөг	0	8,117,982.04
41360	Бусад өглөг	0	8,117,982.04
41361	Байгууллагад төлөх өглөг	0	8,034,682.04
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0	83,300.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,267,518,552.19	9,490,954,571.61
51	Засгийн газрын хувь оролцоо	10,267,518,552.19	9,490,954,571.61
51100	Засгийн газрын оруулсан капитал	816,099,394.39	816,099,394.39
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	816,099,394.39	816,099,394.39
51200	Хуримтлагдсан үр дүн	9,273,418,049.43	8,671,297,440.79
51210	Өмнөх үеийн үр дүн	9,502,184,832.04	9,273,418,049.43
51220	Тайлант үеийн үр дүн	-228,766,782.61	(602,120,608.64)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	178,001,108.37	3,557,736.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,267,518,552.19	9,499,072,553.65

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,426,674,000.00	1,496,384,964.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0	12,089,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	0	12,089,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0	12,089,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	10,609,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0	1,480,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,426,674,000.00	1,484,295,464.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0	888,761,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0	888,761,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,925,000.00	41,919,464.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид	0	31,952,964.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	7,100,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,825,000.00	9,966,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,417,749,000.00	553,614,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн	1,417,749,000.00	553,614,700.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,655,440,782.61	1,779,764,095.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,655,440,782.61	1,779,764,095.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,576,924,674.02	1,775,611,726.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	700,684,582.91	744,615,272.52
210101	Үндсэн цалин	473,509,734.74	512,542,438.98
210102	Нэмэгдэл	179,180,664.50	178,400,988.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	47,994,183.67	39,471,000.00
210104	Урамшуулал	0	14,200,845.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	92,225,766.50	90,618,961.14
210201	Тэтгэврийн даатгал	64,350,140.18	63,090,688.82
210202	Тэтгэмжийн даатгал	7,158,789.28	7,132,010.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,659,830.84	5,658,568.36
210204	Ажилгүйдлийн даатгал	1,343,959.83	1,282,013.86
210205	Эрүүл мэндийн даатгал	13,713,046.37	13,455,679.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	499,990,882.00	545,538,582.04
210301	Гэрэл, цахилгаан	5,869,562.00	8,358,081.04
210302	Түлш, халаалт	489,060,000.00	528,724,538.00
210303	Цэвэр, бохир ус	5,061,320.00	8,455,963.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,541,900.00	6,685,449.00
210401	Бичиг хэрэг	4,027,600.00	1,552,999.00
210402	Тээвэр, шатахуун	1,006,260.00	2,532,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,508,040.00	1,230,450.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	0	1,370,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0	1,894,650.00
210604	Урсгал засвар	0	1,894,650.00
2107	Томилолт, зочны зардал	72,000.00	499,800.00
210702	Дотоод албан томилолт	72,000.00	499,800.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	34,987,994.73	143,926,387.15
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	33,402,234.73	143,926,387.15
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	242,421,547.88	241,832,624.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	547,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	242,421,547.88	241,285,524.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,516,108.59	4,152,368.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,607,300.00	768,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43,309,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	298,300.00	768,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад	34,908,808.59	3,384,368.78
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,905,778.59	3,384,368.78
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,030.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-228,766,782.61	-283,379,131.01
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	318,741,477.63
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0	305,971,477.63
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	0	12,770,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-228,766,782.61	-602,120,608.64

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,426,674,000.00	1,494,988,264.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0	10,692,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	0	10,692,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0	10,609,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	10,609,500.00
120009	Бусад орлого	0	83,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,426,674,000.00	1,484,295,464.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0	888,761,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0	888,761,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,925,000.00	41,919,464.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	31,952,964.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,100,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,825,000.00	9,966,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,417,749,000.00	553,614,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,417,749,000.00	553,614,700.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,426,674,000.00	1,489,215,459.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,426,674,000.00	1,489,215,459.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,348,157,891.41	1,485,063,090.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	700,684,582.91	744,615,272.52
210101	Үндсэн цалин	473,509,734.74	512,542,438.98
210102	Нэмэгдэл	179,180,664.50	178,400,988.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	47,994,183.67	39,471,000.00
210104	Урамшуулал	0	14,200,845.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,225,766.50	90,618,961.14
210201	Тэтгэврийн даатгал	64,350,140.18	63,090,688.82
210202	Тэтгэмжийн даатгал	7,158,789.28	7,132,010.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,659,830.84	5,658,568.36
210204	Ажилгүйдлийн даатгал	1,343,959.83	1,282,013.86
210205	Эрүүл мэндийн даатгал	13,713,046.37	13,455,679.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	499,990,882.00	537,503,900.00
210301	Гэрэл, цахилгаан	5,869,562.00	8,358,081.04
210302	Түлш, халаалт	489,060,000.00	520,689,855.96
210303	Цэвэр, бохир ус	5,061,320.00	8,455,963.00

2104	Хангамж, бараа материалын зардал	11,130,000.00	6,369,300.00
210401	Бичиг хэрэг	4,475,100.00	1,210,302.00
210402	Тээвэр, шатахуун	1,006,260.00	2,182,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,508,040.00	1,230,450.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,440,000.00	1,125,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,700,600.00	620,798.00
2105	Нормативт зардал	1,134,000.00	1,134,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,134,000.00	1,134,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	250,000.00	3,700,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0	2,500,000.00
210604	Урсгал засвар	250,000.00	1,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	72,000.00	499,800.00
210702	Дотоод албан томилолт	72,000.00	499,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,670,660.00	82,308,050.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	41,084,900.00	82,308,050.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,140,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	71,500.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	0.00
210807	Газрын төлбөр	191,260.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0	18,313,807.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	18,313,807.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,516,108.59	4,152,368.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,607,300.00	768,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43,309,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	298,300.00	768,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0	1,000,000.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	34,908,808.59	2,384,368.78
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,905,778.59	2,384,368.78
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,030.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0	5,772,804.56
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0	1,680,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	1,680,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0	1,680,000.00
223001	Бусад хөрөнгө	0	1,680,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0	-1,680,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	4,092,804.56
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	4,092,804.56

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	816,099,394.39	178,001,108.37	9,502,184,832.04	10,496,285,334.80
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	816,099,394.39	178,001,108.37	9,502,184,832.04	10,496,285,334.80
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-228,766,782.61	-228,766,782.61
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	816,099,394.39	178,001,108.37	9,273,418,049.43	10,267,518,552.19
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	816,099,394.39	178,001,108.37	9,273,418,049.43	10,267,518,552.19
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын	-816,099,394.39	-178,001,108.37	-9,273,418,049.43	-10,267,518,552.19
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	816,099,394.39	178,001,108.37	9,273,418,049.00	10,267,518,551.76
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0	-174,443,371.94	0	-174,443,371.94
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-602,120,608.64	-602,120,608.64
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	816,099,394.39	3,557,736.43	8,671,297,440.36	9,490,954,571.18

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,490,200,500.00	1,448,364,734.15	41,835,765.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,490,200,500.00	1,446,684,734.15	43,515,765.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,489,432,500.00	1,445,916,734.15	43,515,765.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	737,414,900.00	733,998,229.80	3,416,670.20
210101	Үндсэн цалин	523,731,700.00	501,925,396.26	21,806,303.74
210102	Нэмэгдэл	176,450,700.00	178,400,988.53	-1,950,288.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,476,600.00	39,471,000.00	-17,994,400.00
210104	Урамшуулал	15,755,900.00	14,200,845.01	1,555,054.99
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,176,900.00	89,376,147.35	2,800,752.65
210201	Тэтгэврийн даатгал	62,680,300.00	61,847,875.03	832,424.97
210202	Тэтгэмжийн даатгал	7,374,200.00	7,132,010.77	242,189.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,899,300.00	5,658,568.36	240,731.64
210204	Ажилгүйдлийн даатгал	1,474,900.00	1,282,013.86	192,886.14
210205	Эрүүл мэндийн даатгал	14,748,200.00	13,455,679.33	1,292,520.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	537,503,900.00	537,503,900.00	0.00
210301	Гэрэл, цахилгаан	27,511,500.00	8,358,081.04	19,153,418.96
210302	Түлш, халаалт	489,060,000.00	520,689,855.96	-31,629,855.96
210303	Цэвэр, бохир ус	20,932,400.00	8,455,963.00	12,476,437.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,445,300.00	5,295,300.00	1,150,000.00
210401	Бичиг хэрэг	1,476,100.00	1,210,302.00	265,798.00
210402	Тээвэр, шатахуун	1,008,100.00	1,108,000.00	-99,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,320,000.00	1,230,450.00	89,550.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	1,440,000.00	1,125,750.00	314,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,201,100.00	620,798.00	580,302.00
2105	Нормативт зардал	1,434,000.00	1,134,000.00	300,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,434,000.00	1,134,000.00	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,700,000.00	3,700,000.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,500,000.00	2,500,000.00	0.00
210604	Урсгал засвар	1,200,000.00	1,200,000.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	499,800.00	200.00
210702	Дотоод албан томилолт	500,000.00	499,800.00	200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	70,257,500.00	54,415,550.00	15,841,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	70,257,500.00	54,415,550.00	15,841,950.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,000,000.00	19,993,807.00	20,006,193.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,000,000.00	19,993,807.00	20,006,193.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	768,000.00	768,000.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	768,000.00	768,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	768,000.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	1,680,000.00	-1,680,000.00
223001	Бусад хөрөнгө	0.00	1,680,000.00	-1,680,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,490,200,500.00	1,452,985,500.00	37,215,000.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	888,761,300.00	888,761,300.00	0.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	888,761,300.00	888,761,300.00	0.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	553,614,700.00	553,614,700.00	0.00
320001	Орон нутгийн төсвөөс	553,614,700.00	553,614,700.00	0.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	47,824,500.00	10,609,500.00	37,215,000.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	47,824,500.00	10,609,500.00	37,215,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	0.00	0.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0.00	4,092,804.56	-4,092,804.56

2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,925,000.00	40,826,356.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,925,000.00	40,826,356.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,921,970.00	40,826,356.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		10,617,042.72
210101	Үндсэн цалин		10,617,042.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,242,813.79
210201	Тэтгэврийн даатгал		1,242,813.79
2104	Хангамж, бараа материалын зардал	837,040.00	1,074,000.00
210401	Бичиг хэрэг	649,000.00	00.00
210402	Тээвэр, шатахуун		1,074,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	188,040.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,084,930.00	27,892,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,084,930.00	27,892,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,030.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,030.00	00.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	3,030.00	00.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,925,000.00	40,826,356.51
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,925,000.00	40,826,356.51
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,100,000.00	31,952,964.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,825,000.00	8,873,392.51
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Монгол Туургатан театр нь үндэсний соёл урлагаа уламжлал шинэчлэлээр бататган хөгжүүлж, хүн амд хүргэх үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэн нийгмийн оюуны хэрэгцээг хангах чиг үүрэг бүхий Соёл урлагийн газарт санхүүгийн тайлангаа нэгтгэдэг Соёлын яамны харьяа төрийн байгууллага юм.

Төв аймгийн Монгол Туургатан театр нь үндэсний соёл урлагаа уламжлал шинэчлэлээр баяжуулан хөгжүүлж, хүн амд хүргэх үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэн, бүх талын тааламжтай орчин нөхцөлийг бүрдүүлсэн, орон нутгийн хэмжээнд бүх чиглэлийн тэргүүлэх үйл ажиллагаа явуулдаг театр болох, мэргэжлийн урлагийн байгууллагын уран бүтээлийн чанарыг сайжруулж, уламжлалт үндэстэн ястны бахархалт уран бүтээлүүдээр урийн санг баяжуулан, үзэгчдийн хүртээл болгох зорилго, зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус театр нь 2022 онд Ш.Гүрбазарын “Шар гэгээ” драмын жүжиг, Их зохиолч Д.Нацагдорж, Төрийн хошой шагналт, Ардын жүжигчин Б.Дамдинсүрэн нарын “Учиртай гурван толгой” дуурь, Оросын нэрт зохиолч Панфилова Рыжковагийн “Шившлэгтэй зургийн нууц” хүүхдийн жүжиг, Их зохиолч Д.Нацагдоржийн “Ламбугайн нулимс” дуурь зэргийг шинээр болон сэргээн тавьж, үзэгчдийн хүртээл болгон, 1 бүтээл сэргээн, 3 бүтээлийг шинээр найруулан тавьж, нийт 4 уран бүтээлээр урын сангаа баяжуулан 12716 иргэнд үйлчилсэн байна. Үзэгч өмнөх оноос 1.5 хувиар, боловсон хүчний хангалт 0.7 хувиар ахисан амжилттай байна.

Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь 3 зорилт 35 арга хэмжээтэй боловсруулан, хэрэгжүүлж ба жилийн эцсийн байдлаар 88,8 хувьтай хэрэгжсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус театр нь Соёлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон Ёс зүйн зөвлөлийн дүрэм, ХАБЭХ-н дүрэм, Уран сайхны зөвлөлийн дүрэм зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын дотоод журам болон холбогдох баримт бичигт өөрчлөлт оруулан мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж дүгнэлээ.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Монгол Туургатан театр нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Монгол Туургатан театр нь Соёл, спорт аялал жуулчлалын сайдын 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/465 дугаар тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад бүрэн нийцээгүй, 2013 оноос хойш холбогдох хууль тогтоомжид орсон өөрчлөлт хийгдээгүй, байгууллагын онцлогт тохирохгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Монгол Туургатан театр нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 768,446.0 мянган төгрөгөөр буюу 7,5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	4,092.8	4,092.8
Авлага	1,995.2	2,348.6	353.4
Бараа материал	393,660.1	339,488.3	- 54,171.8
Үндсэн хөрөнгө	9,871,863.2	9,153,142.8	- 718,720.4
Нийт хөрөнгө	10,267,518.5	9,499,072.5	- 768,446.0
Өр төлбөр		8,117.9	8,117.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	10,267,518.5	9,490,954.6	- 776,563.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10,267,518.5	9,499,072.5	- 768,446.0

Дээрх хүснэгтээс харахад бараа материалын үлдэгдэл 339,488.3 мянган төгрөг болж 54,171.8 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагын даргын 2022 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А/21 дугаар тушаалаар байгууллагын цаашид ашиглагдах боломжгүй болсон 95,641.4 мянган төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассан, аймгийн ИТХ-ын 2022 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор 1,080.0 мянган төгрөгийн хөрөнгийг Зуунмод сумын Соёлын төвд үнэ төлбөргүй шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө 9,152,142.8 мянган төгрөг болж 718,720.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд аймгийн ИТХ-ын 2022 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор 680,562.7 мянган төгрөгийн хуучин театрын хөрөнгийг Зуунмод сумын Соёлын төвд үнэ төлбөргүй шилжүүлснээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,677,553.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 235,177.7 мянган төгрөгөөр бууруулж, улсын төсвөөс 888,761.3 мянган төгрөг Орон нутгийн төсвөөс 553,614.7 мянган төгрөг бүгд 1,442,376.0 мянган төгрөгөөр баталсан байна. Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө батлагдаагүй байна.

Энэ нь 2022 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй эсвэл нийт төсөв буурч батлагдсанаас шалтгаалсан байна.

Тайлант хугацаанд батлагдсан төсөвт Соёлын яамнаас 20,000.0 мянган төгрөгийг нэмж 1 удаа өөрчлөлт хийгдсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 235,177.7 мянган төгрөгөөр бууруулж 1,442,376.0 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Соёл хөтөлбөрийн Үндсэн үйл ажиллагааны зардал, уран бүтээл, ажил олгогчоос тэтгэмж урамшууллын зардал, Төрийн өмчийн барилгын тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал арга хэмжээг санхүүжүүлэхээр 888,761.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 553,614.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 888,761.3 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 553,614.7 мянган төгрөгийн, Засаг даргын нөөц хөрөнгөөс 34,152.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлогоор 18,376.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,490,895.5 мянган төгрөг буюу 99,8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвөөс 4,092.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 2,384.4 мянган төгрөгийг дутуу зарцуулсантай холбоотой байна. Тайлант оны эцэст орон нутгийн төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 2,384.4 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны дансанд аймгийн Засаг даргын 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн А/357 тоот тушаалаар 2,200.0 мянган төгрөгийг Олон улсын театрын урлагийн наадмын Гэгээн муза-16 арга хэмжээнд оролцох зардлыг санхүүжүүлэн зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71702/ 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	847,993,3	847,993,3	0	100%
2	71702/ 80214 Уран бүтээл хийлгэх	40,000,0	40,000,0	0	100%
3	71702/ 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардал	768,0	768,0	0	100%
4	71702/ 80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	538,703,9	538,703,9	0	100%
5	71702/ 83603 Дээд шатны төсвөөс хуваарилсан		39,044,0	0	100%
6	71702/ 80112 Нийтлэг үйлчилгээ	14,910,8	24,386.2	9475.4	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/153 дугаар захирамжаар Лам гуайн нулимс үндэсний дуурийг шинээр дэглэн тавихад 20,000.0 мянган төгрөгийг, 11,952.9 мянган төгрөгийг төрийн үйлчилгээний ажиллагсдын цалин, шимтгэлийн зардалд хуваарилан санхүүжүүлсэн байна.

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого 9,966.5 мянган төгрөгийг төвлөрүүлэн зарцуулж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 1,093.1 мянган төгрөгийн улсын төсвийн дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд шүүхийн шийдвэр гүйцэтгэл хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Тайлант онд хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэн батлагдсан төсвийг 98,7 хувьтай зарцуулсан байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Соёл урлаг/71702/	12 сар	Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах	Хөтөлбөр 99,8 %	1,497,490,9	1,490,895,4

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Монгол Туургатан театрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Монгол Туургатан театр нь 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 06 дугаар албан бичгээр 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Соёлын яамны 2022 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Монгол Туургатан театрын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийн 2022 оны нийт зарлага 1,442,386.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 21,635.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 16,226.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

Тайлант оны эцэст зарцуулаагүй 4,092.8 мянган төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлээгүй, мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр тайлагнасан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад тайлант хугацаанд цахим хуудсанд байршуулбал зохих 4 мэдээллийг байршуулаагүй, 3 мэдээлэл хугацаа

хоцроосон төлөвтэй байна. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 31,809.7 мянган төгрөгийн 5 шийдвэр байршуулаагүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Монгол Туургатан театрын 2022 оны эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Төв аймгийн Монгол Туургатан театрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 төлбөрийн акт, 1 албан шаардлага өгөгдсөнийг хэрэгжүүлэн, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 24-ны өдөр 58 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1,995.2	2	1,995.2	
Албан шаардлага	1	19,683.5	1	19,683.5	100
Зөвлөмж					
Нийт дүн	3	21,678.7	3	21,678.7	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Монгол Туургатан театрын дараагийн аудитаар шатахууны тайлан гаргалт, жолоочийн замын хуудасны тооцоо бодолтод анхаарал хандуулах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 159,578.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 159,578.6 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

1.Санхүүгийн тайланд төсвийн гүйцэтгэлийн тайланг тохируулаагүй, бараа материалын үлдэгдлийг 24,405.6 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгийн данснаас үнэ төлбөргүй шилжүүлсэн зардлыг буруу бичилт хийж үр дүнг 135,173.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “толилуулга”, “оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 51,642.6 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 11,798.2 мянган төгрөгийн төлбөрийн акт, 8,034.7 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 31,809.7 мянган төгрөгийн зөвлөмж өгөгдсөн.

5.1 Төлбөрийн акт

1.Харилцагч байгууллагатай хийх төлбөр тооцоог хянаагүйгээс нийгмийн даатгалын шимтгэлийн 2,025.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”; Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5-д “Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэж заасны дагуу төлбөрийн акт тогтоов.

2.Тайлант хугацаанд олгосон 9,773.2 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа суутгаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”; Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5-д “Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэж заасны дагуу төлбөрийн акт тогтоов.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага

1.Тайлант онд түлш халаалтын 8,034.7 мянган төгрөгийн өглөгийг үүсгэж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”; Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.7-д “авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байх” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 4 мэдээллийг байршуулаагүй, 3 мэдээлэл хугацаа хоцроосон төлөвтэй байна. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 31,809.7 мянган төгрөгийн 5 шийдвэр байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" гэж заасантай бүрэн нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн мэдээлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаа гүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
буруу	2	159,578.6			2	159,578.6	2	159,578.6				
Дүн	2	159,578.6			2	159,578.6	2	159,578.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төлбөрийг илүү төлж, авлага үүсгэсэн	1	2,025.0	1	2,025.0								
Урьдчилгаа суутгаагүй	1	9,773.2	1	9,773.2								
Шинээр өр үүсгэсэн	1	8,034.7			1	8,034.7						
Дүн	3	19,832.9	2	11,798.2	1	8,034.7						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дутуу мэдээлсэн	1	31,809.7					1	31,809.7
Дүн	1	31,809.7					1	31,809.7
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	31,809.7					1	31,809.7